



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2023/28-11-ШТА-ГА/ тайланг хавсралтаар баталгаажуулсугай..
2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг Дүүргийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг гүйцэтгэл-нийцлийн хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.
4. Тайланг Үндэсний аудитын газар, Дүүргийн Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАХ-г батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны хариуцлагагүй байдал нь төсвийн хөрөнгө үр дүн, үр ашиггүй зарцуулагдах нөхцөлийг бий болгож байна.





**АУДИТЫН СЭДЭВ: ДҮҮРГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Улаанбаатар хот  
2023 он

НТАГ-2023/28-11-ШТА-ГА

Дүүргийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

|  |  |       |
|--|--|-------|
| Аудитын тайланг бэлтгэсэн:   | Товчилсон үг   | 2     |
| Нийслэл дэх Төрийн аудитын газар   | Хүснэгтийн жагсаалт  | 3     |
|  | Графикийн жагсаалт   | 3     |
| Гүйцэтгэл-нийцлийн хэлтэс  | Хавсралтын жагсаалт  | 3     |
| Хэлтсийн дарга, аудитын менежер:   | Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл  | 4     |
|  Э.Мөнхмандах<br>Аудитын менежер: | Ерөнхий мэдээлэл   | 5-6   |
|  Л.Саранбаатар<br>Аудитор:        | В.1 Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх   | 7     |
|  С.Анужин                         | В.1.1 Төсөл, арга хэмжээ нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу?                 | 7-8   |
|  М.Одгэрэл                        | В.1.2. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?            | 9-11  |
|  О.Оргил                         | В.2 Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй эсэх   | 12    |
| Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787                                       | В.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан уу?  | 12-16 |
| Тайланг НТАГ-ын <a href="http://www.audit.mn/">http://www.audit.mn/</a> веб сайтаас үзнэ үү.                       | В.2.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй байна уу?   | 17-19 |
|  | В.2.3. Санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон уу?   | 20-21 |
|  | В.2.4 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?                                  | 22-23 |
|  | В.2.5 Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу? | 23-24 |
|  | Аудитын дүгнэлт  | 25    |
|  | Аудитын зөвлөмж  | 25    |
|  | Холбогдох байгууллагын санал   | 26-27 |
|  | Саналд өгсөн тайлбар   | 28    |
|  | Хавсралтууд  | 29-42 |

Товчилсон үг

|               |  |
|---------------|--|
| АДБОУС        | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт  |
| БГД           | Баянгол дүүрэг   |
| БЗД           | Баянзүрх дүүрэг  |
| БНД           | Багануур дүүрэг  |
| БХД           | Багахангай дүүрэг  |
| ДИТХ          | Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал  |
| ДЗД           | Дүүргийн Засаг дарга   |
| ЗГ            | Засгийн газар  |
| ЗД            | Засаг дарга  |
| ЗДТГ          | Засаг даргын тамгын газар  |
| МУЕА          | Монгол Улсын Ерөнхий аудитор   |
| ИТХ           | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал   |
| НД            | Налайх дүүрэг  |
| НЗХГ          | Нийслэлийн замын хөгжлийн газар  |
| НХААГ         | Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар   |
| НХОГ          | Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар  |
| НТАГ          | Нийслэл дэх Төрийн Аудитын газар   |
| НҮТББ         | Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага   |
| ОНӨААТҮГ      | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                                       |
| СБД           | Сүхбаатар дүүрэг   |
| СХД           | Сонгинохайрхан дүүрэг  |
| СТСХ          | Санхүү, төрийн сангийн хэлтэс  |
| ТАХ           | Төсөл, арга хэмжээ   |
| ТББ           | Тендерийн баримт бичиг   |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТГҮХ          | Төлөвлөлт, гүйцэтгэл удирдлагын хэлтэс   |
| ТШЗ           | Тендер шалгаруулалтын зааварчилгаа   |
| ТШОЖ          | Тендер шалгаруулалтын онцгой журам   |
| ХАА           | Худалдан авах ажиллагаа  |
| ХААА          | Худалдан авах ажиллагааны алба   |
| ХУД           | Хан-Уул дүүрэг   |
| ЧД            | Чингэлтэй дүүрэг   |

### Хүснэгтийн жагсаалт

| Дугаар     | Гарчиг   | Хуудас |
|------------|--|--------|
| Хүснэгт 1  | 2021, 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний харьцуулалт   | 5      |
| Хүснэгт 2  | Шинээр төлөвлөсөн ТАХ-г ангилсан байдал  | 7      |
| Хүснэгт 3  | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд тусгагдаагүй ТАХ-ний тоо                  | 8      |
| Хүснэгт 4  | Дүүргүүдийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй нийцүүлэн тусгаагүй ТАХ-ний тоо | 8      |
| Хүснэгт 5  | Өмчлөлд шилжих боломжгүй ТАХ   | 9      |
| Хүснэгт 6  | 2022 онд хэрэгжих ТАХ-г салбараар эрэмбэлсэн байдал  | 10     |
| Хүснэгт 7  | Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ   | 10     |
| Хүснэгт 8  | Газрын зөвшөөрөлгүй ТАХ  | 11     |
| Хүснэгт 9  | Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ   | 11     |
| Хүснэгт 10 | Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ  | 12     |
| Хүснэгт 11 | Хүчингүй болсон тендерийн бичиг баримтаар худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ажлууд                           | 13     |
| Хүснэгт 12 | Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам  | 14     |
| Хүснэгт 13 | 2022 онд хэрэгжсэн, он дамжсан, хэрэгжээгүй ТАХ  | 17     |
| Хүснэгт 14 | ТАХ-ний санхүүжилтийн судалгаа   | 20     |
| Хүснэгт 15 | 2022 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги  | 20     |
| Хүснэгт 16 | Магадлал, тодотголоор нэмэгдсэн санхүүжилтийн дүн  | 21     |
| Хүснэгт 17 | Гүйцэтгэлийн шатанд баталгаажуулсан актууд   | 22     |
| Хүснэгт 18 | Хэрэгжсэн ТАХ-ээс бүртгэлд тусгасан байдал   | 23     |

### Графикийн жагсаалт

| Дугаар   | Гарчиг                        | Хуудас |
|----------|-------------------------------|--------|
| График 1 | Шинээр төлөвлөсөн ТАХ-ний тоо | 7      |

### Хавсралтын жагсаалт

| Дугаар     | Гарчиг  | Хуудас |
|------------|---|--------|
| Хавсралт 1 | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгаагүй ТАХ                    | 29-31  |
| Хавсралт 2 | ЗД-ын мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй ТАХ                    | 31-32  |
| Хавсралт 3 | Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус ТАХ  | 32-34  |
| Хавсралт 4 | Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ  | 35-37  |
| Хавсралт 5 | 2022 оны 10 дугаар сараас хойш гэрээ байгуулсан дуусаагүй ТАХ                                   | 37-39  |
| Хавсралт 6 | Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой гарсан зөрчил | 39-42  |

|   |   |
|---|---|
| <p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>     | <p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b></p> <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, НТАГ-ын 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн хийв.</p>   |
| <p>Аудитын зорилт</p>                     | <p>Аудитын зорилт Дүүргийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:</p>  |
| <p>Аудитын хамарсан хүрээ</p>             | <ul style="list-style-type: none"><li>✚ Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх</li><li>✚ Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй эсэх</li></ul> <p>Аудитыг дүүргүүдийн ЗДТГ-ын СТСХ, ТГУХ, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Худалдан авах ажиллагааны албадыг хамруулан гүйцэтгэлээ.</p>  |
| <p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p> | <p>Аудитыг АДБООУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p> |
| <p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>       | <p>Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, аудитор С.Анужин ахлан, аудитор М.Одгэрэл, О.Оргил нар гүйцэтгэв.</p>   |

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дүүргүүдийн төсвийн хөрөнгөөр 2022 онд нийт 224,740.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 485 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан.

Үүний 135,429.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 310 ТАХ нь шинээр, 89,310.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 175 ТАХ өмнөх оноос дамжин хэрэгжиж буй ТАХ байна.

Дээрх ТАХ-ээс 11.0% буюу 53 нь барилга, байгууламж, 24.5% буюу 119 нь тоног төхөөрөмж, 7.2% буюу 35 нь авто зам дэд бүтэц, 16.9% буюу 82 нь тохижилт, 17.8% буюу 86 нь засвар, 14.4% буюу 70 нь зураг төсөв боловсруулах, 8.2% буюу 40 нь бусад ажил байна.

Шинээр хэрэгжих 310 ТАХ-г шинж чанараас хамааруулан төсөвт өртгийг задлах, хуваах байдлаар ХАА-г зохион байгуулж, батлагдсан 310 ТАХ-ний тоо 139,161.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 424 ТАХ болсон байна.

Үүнээс 2022 онд 101,695.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 352 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

Харин 19,585.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 44 ТАХ-ний ХАА зохион байгуулах ажил тухайн онд дуусаагүй, 17,880.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 ТАХ нь зураг төсөв, ажлын даалгаваргүй зэргээс хэрэгжээгүй байна.

Өмнөх оноос дамжин хийгдсэн болон 2022 онд шинээр эхэлсэн нийт 171,082.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 518 ТАХ-нд дүүргүүдийн ЗДТГ болон “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, “Хүн төвтэй хот төлөвлөлтийн лаборатори” НҮТББ, “Сэтгэшгүй нэмэх” ХХК, “Захиалагчийн алба” ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

2022 онд 61,066.5 сая төгрөгийн дүнтэй 355 ТАХ хэрэгжиж дууссан, 80,746.4 сая төгрөгийн дүнтэй 92 ТАХ хэрэгжилт дутуу 2023 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа, 19,774.9 сая төгрөгийн 71 ТАХ хэрэгжээгүй байна.

Дүүргүүдийн ТАХ-ны батлагдсан тоо өмнөх онтой харьцуулахад 210 ТАХ-ээр, төсөвт өртөг 135,153.5 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт 1. 2021, 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний харьцуулалт**

| № | Дүүргийн нэр | 2021 он          |                 | 2022 он          |                   | /сая.төг/<br>Өсөлт, бууралт |                  |
|---|--------------|------------------|-----------------|------------------|-------------------|-----------------------------|------------------|
|   |              | Баталсан ТАХ тоо | Төсөвт өртөг    | Баталсан ТАХ тоо | Төсөвт өртөг      | ТАХ тоо                     | Төсөвт өртөг     |
| 1 | БГД          | 44               | 16,023.40       | 59               | 12,851.10         | 15                          | -3,172.30        |
| 2 | БЗД          | 12               | 4,542.7         | 70               | 56,509.10         | 58                          | 51,966.4         |
| 3 | БНД          | 35               | 1,015.6         | 59               | 3,517.70          | 24                          | 2,502.1          |
| 4 | БХД          | 6                | 162.1           | 11               | 390.2             | 5                           | 228.1            |
| 5 | НД           | -                | -               | 25               | 1,312.10          | 25                          | 1,312.1          |
| 5 | СБД          | 58               | 31,765.5        | 59               | 40,841.80         | 1                           | 9,076.3          |
| 6 | СХД          | 20               | 5,820.7         | 28               | 13,379.50         | 8                           | 7,558.8          |
| 7 | ЧД           | 32               | 20,761.8        | 73               | 59,922.40         | 41                          | 39,160.6         |
| 8 | ХУД          | 68               | 9,494.9         | 101              | 36,016.30         | 33                          | 26,521.4         |
|   | <i>Нийт</i>  | <b>275</b>       | <b>89,586.7</b> | <b>485</b>       | <b>224,740.20</b> | <b>210</b>                  | <b>135,153.5</b> |

Аудитын түүврийг хийхдээ МУЕА-ын 2018 оны А/351 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу эх олонлогийг бүхэлд нь хамруулах үүднээс 2022 онд хэрэгжсэн ТАХ-ний төсөвт өртөг болон төрөл тус бүрээс хамруулсан. Үүнд:

- 2022 онд шинээр төлөвлөгдсөн 135,429.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 310 ТАХ-г бүрэн хамруулсан;
- Худалдан авалт амжилттай зохион байгуулсан 352 ТАХ-ээс 89,806.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 190 ТАХ буюу 53.9%-ийг аудитын түүвэрт хамруулсан;
- Гэрээний хэрэгжилт: 2022 онд бүрэн дууссан, санхүүжилт олгосон 61,066.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 355 ТАХ-ээс 50.4% буюу 179-г түүвэрт хамруулсан;
- Шинээр болон он дамжин хэрэгжих 485 ТАХ-г 180,395.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 411 ТАХ-нд олгосон 104,768.1 сая төгрөгийн санхүүжилт, барьцаа хөрөнгө, хүү алданги торгууль, техникийн болон захиалагчийн хяналтын зардлыг 100% тулган баталгаажуулсан.

## БҮЛЭГ В1. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН ЭСЭХ

### В.1.1 Төсөл, арга хэмжээ нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу?

Төсвийн тухай хуулийн 12.1.4<sup>1</sup>, 6.5<sup>2</sup>, 67.3<sup>3</sup> дахь заалтын дагуу “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Дүүргүүдийн ЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд дүүргүүд 2022 оны төсвийг баталжээ. 2022 онд 135,429.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 310 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр байна.

#### Хүснэгт 2. Шинээр төлөвлөсөн ТАХ-г ангилсан байдал

| № | Ангилал             | Тоо        | Төсөвт өртөг     | Эзлэх хувь /сая.төг/ |
|---|---------------------|------------|------------------|----------------------|
| 1 | Барилга байгууламж  | 30         | 25,701.9         | 9.7%                 |
| 2 | Авто зам, Дэд бүтэц | 30         | 29,301.4         | 9.7%                 |
| 3 | Засвар              | 54         | 12,659.6         | 17.4%                |
| 4 | Зураг төсөв         | 26         | 2,834.4          | 8.4%                 |
| 5 | Тоног төхөөрөмж     | 82         | 29,616.3         | 26.5%                |
| 6 | Тохижилт            | 51         | 19,423.0         | 16.4%                |
| 7 | Бусад               | 37         | 15,892.9         | 11.9%                |
|   | <b>Нийт</b>         | <b>310</b> | <b>135,429.5</b> | <b>100%</b>          |

Эдгээр ТАХ-ээс “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 188 ТАХ буюу 60.6%, “Дүүргүүдийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 253 ТАХ буюу 81.6% нь нийцсэн байна.



#### В.1.1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, ДЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй нийцэж байна уу?

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 310 ТАХ-г хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- **Дунд хугацааны баримт бичиг:** “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 188 буюу 60.6%, “Дүүргүүдийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 253 буюу 81.6% ТАХ нь уялдсан байна.

<sup>1</sup>12.1.4.жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг төсвийн цаглаврыг баримтлан бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

<sup>2</sup>6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

<sup>3</sup>67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

- **Богино хугацааны баримт бичиг:** Дүүргүүдийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухайн жилийн төлөвлөгөөнд 215 буюу 69.3% ТАХ нь уялдсан байна. Хавсралт 1, 2

**Хүснэгт 3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд тусгагдаагүй ТАХ-ний тоо**

| № | Дүүргийн нэр | Нийт ТАХ-ний тоо | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан эсэх |            | ДЗД-ийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тусгагдсан эсэх |           |
|---|--------------|------------------|--|------------|--|-----------|
|   |              |                  | Тусгасан   | Тусгаагүй  | Тусгасан   | Тусгаагүй |
| 1 | БГД          | 16               | 14   | 2          | 14   | 2         |
| 2 | БЗД          | 64               | 36   | 8          | 56   | 8         |
| 3 | БНД          | 38               | 10   | 28         | 20   | 18        |
| 4 | БХД          | 11               | 11   | -          | 11   | -         |
| 5 | НД           | 23               | 2  | 21         | 7  | 16        |
| 6 | СБД          | 38               | 34   | 4          | 38   | -         |
| 7 | СХД          | 18               | 11   | 7          | 11   | 7         |
| 8 | ХУД          | 43               | 39   | 4          | 38   | 5         |
| 9 | ЧД           | 59               | 58   | 1          | 58   | 1         |
|   | <b>Нийт</b>  | <b>310</b>       | <b>188</b>   | <b>122</b> | <b>253</b>   | <b>57</b> |

**Дүгнэлт:** 2022 онд хэрэгжихээр батлагдсан 310 ТАХ-нээс хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд дунджаар 71.1% нь нийцсэн байна.

**В.1.1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг "Дүүргийн засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-тэй нийцүүлэн төлөвлөсөн үү?**

Дүүргүүдийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухайн жилийн төлөвлөгөөнд 215 буюу 69.3% ТАХ-г нийцүүлэн төлөвлөсөн байна.

**Хүснэгт 4. ДЗД-ын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй нийцүүлсэн ТАХ-ний тоо**

| № | Дүүргийн нэр | Нийт ТАХ-ний тоо | 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан эсэх |           |
|---|--------------|------------------|---|-----------|
|   |              |                  | тусгасан  | тусгаагүй |
| 1 | БГД          | 16               | 14  | 2         |
| 2 | БЗД          | 64               | 18  | 46        |
| 3 | БНД          | 38               | 19  | 19        |
| 4 | БХД          | 11               | 8   | 3         |
| 5 | НД           | 23               | 12  | 11        |
| 6 | СБД          | 38               | 38  | -         |
| 7 | СХД          | 18               | 10  | 8         |
| 8 | ХУД          | 43               | 38  | 5         |
| 9 | ЧД           | 59               | 58  | 1         |
|   | <b>Нийт</b>  | <b>310</b>       | <b>215</b>  | <b>95</b> |

**Дүгнэлт:** 2022 онд хэрэгжихээр батлагдсан 310 ТАХ-нээс хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд 69.3%-нь нийцсэн байна.

## В.1.2. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?

2022 онд хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.4.5, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 4.1.27, 6 дугаар зүйлийн 6.6.5, 6.6.6 дахь заалтууд, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийг баримтлаагүй байна.

ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, зураг төсөв батлагдаагүй, техникийн нөхцөл, газрын асуудал шийдвэрлэгдээгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай болон улсын төсвийн байгууллагад хөрөнгө оруулалт хийх зэрэг ТАХ-г төлөвлөсөн нь нийт ТАХ-ний 22,451.3 сая төгрөгийн төсөвт өртөг буюу 25.8% байна.

### В.1.2.1 Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?

2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 310 ТАХ-ээс төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой 230 ТАХ, шилжих боломжгүй 80 ТАХ төлөвлөсөн байна. Хавсралт 3

**Хүснэгт 5. Өмчлөлд шилжих болон боломжгүй ТАХ**

| № | Дүүргийн нэр | Өмчид шилжих боломжтой | Төсөвт өртөг | /сая.төг/                |              |
|---|--------------|------------------------|--------------|--------------------------|--------------|
|   |              |                        |              | Өмчлөлд шилжих боломжгүй | Төсөвт өртөг |
| 1 | БГД          | 13                     | 3,600.0      | 3                        | 1,350.0      |
| 2 | БЗД          | 54                     | 50,711.3     | 10                       | 2,434.5      |
| 3 | БНД          | 14                     | 572.3        | 25                       | 2,297.0      |
| 4 | БХД          | 9                      | 345.6        | 2                        | 44.5         |
| 5 | НД           | 12                     | 896.5        | 11                       | 393.6        |
| 6 | СБД          | 35                     | 16,329.8     | 3                        | 259.0        |
| 7 | СХД          | 15                     | 7,704.2      | 3                        | 910.0        |
| 8 | ХУД          | 28                     | 21,739.1     | 14                       | 6,299.0      |
| 9 | ЧД           | 50                     | 10,596.9     | 9                        | 8,463.7      |
|   | нийт         | 230                    | 112,495.7    | 80                       | 22,451.3     |

**Дүгнэлт:** 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний 25.8%-ийг тухайн байгууллагын өмчлөлд шилжих боломжгүй буюу хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-г төлөвлөсөн байна.

### В.1.2.2 ТАХ-ны ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн үү?

Дүүргүүд 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 485 ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Дүүргүүд нь 2022 онд хэрэгжүүлэх ТАХ-ний саналыг олон нийтээс авах ажлыг 2021 оны эхний улиралд зохион байгуулж, ИТХ-аараа хэлэлцүүлэн эрэмбэлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаал баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4<sup>4</sup>, 4.5<sup>5</sup>, 5 дугаар зүйлийн 5.10<sup>6</sup>-д заасны дагуу ТАХ-г эрэмбэлэхдээ өмнөх оноос хэрэгжсэн ТАХ, их засвар, шинээр

<sup>4</sup> 4.4 Төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтлана. Үүнд:

<sup>5</sup> 4.5 Төсөл нь холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

<sup>6</sup> 5.10. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь төсөвт тусгах хөрөнгө оруулалтын төслийг тодорхойлж, шийдвэрлэхдээ энэхүү журмын 4.4-т заасан эрэмбийг баримтлах үүрэгтэй;

хэрэгжүүлэх ТАХ гэсэн дарааллаар, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлийн төслүүд байх гэсэн үзүүлэлтийг харгалздаг байна.

Дээрх 9 дүүрэгт 2022 онд хэрэгжих шинэ болон шилжих 224,740.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 485 ТАХ-г аудитаар эрэмбэлсэн эсэхийг тулгахад дараах байдалтай байна.

Хүснэгт 6. 2022 онд хэрэгжих ТАХ-г салбараар эрэмбэлсэн байдал

| /сая.төг/   |   |                     |                   |                  |            |
|-------------|---|---------------------|-------------------|------------------|------------|
| №           | Дүүргийн нэр                                    | Ангилал             | Шилжих болон шинэ | Төсөвт өртөг     | Эзлэх хувь |
| 1           |   | Барилга байгууламж  | Шилжих            | 50,200.3         | 22.3       |
|             |   |                     | Шинэ              | 25,701.9         | 11.4       |
| 2           |   | Авто зам, Дэд бүтэц | Шилжих            | 6,193.1          | 2.7        |
|             |   |                     | Шинэ              | 29,301.4         | 13.0       |
| 3           |   | Засвар              | Шилжих            | 3,652.3          | 1.6        |
|             |   |                     | Шинэ              | 12,659.6         | 5.6        |
| 4           | БГД, БЗД, БНД,<br>БХД, НД, СБД,<br>СХД, ХУД, ЧД | Зураг төсөв         | Шилжих            | 2,729.3          | 1.2        |
|             |   |                     | Шинэ              | 2,834.4          | 1.3        |
| 5           |   | Тоног төхөөрөмж     | Шилжих            | 7,867.7          | 3.5        |
|             |   |                     | Шинэ              | 29,616.3         | 13.2       |
| 6           |   | Тохижилт            | Шилжих            | 5,296.6          | 2.4        |
|             |   |                     | Шинэ              | 19,423.0         | 8.7        |
| 7           |   | Бусад               | Шилжих            | 13,371.7         | 6.0        |
|             |   |                     | Шинэ              | 15,892.9         | 7.1        |
| <b>НИЙТ</b> |   |                     |                   | <b>224,740.5</b> | <b>100</b> |

ТАХ-г эрэмбэлсэн байдлыг авч үзэхэд барилга байгууламж /хороо өрхийн эмнэлгийн байр/ 33.7%, техник тоног төхөөрөмж 16.7%, автозам, дэд бүтцийг сайжруулах ажил 15.7% зэрэг ач холбогдолоор нь жагсаасан байна.

**Дүгнэлт:** Дүүргүүд нь 2022 онд хэрэгжүүлэх ТАХ-г олон нийтийн саналд үндэслэн ач холбогдол, эрэмбэ, дарааллыг баримтлан төсөвт тусгасан байна.

### В.1.2.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгасан уу?

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 310 ТАХ-ээс зураг төсөв шаардлагатай 153 ТАХ байна. Үүнээс 32,131.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 нь зураг төсөвтэй, 54,339.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 91 нь зураг төсөвгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>7</sup> дэх заалтуудыг зөрчжээ. Хавсралт 4

Хүснэгт 7. Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ

| /сая.төг/   |              |                              |                |                       |                 |
|-------------|--------------|------------------------------|----------------|-----------------------|-----------------|
| №           | Дүүргийн нэр | Зураг төсөв шаардлагатай ТАХ |                | Үүнээс зураг төсөвгүй |                 |
|             |              | Тоо                          | Төсөвт өртөг   | Тоо                   | Төсөвт өртөг    |
| 1           | БГД          | 15                           | 4750.0         | 12                    | 2,660.0         |
| 2           | БЗД          | 45                           | 37949.7        | 44                    | 33,449.8        |
| 3           | БНД          | 1                            | 20.0           | 1                     | 20.0            |
| 4           | БХД          | 2                            | 46.2           | -                     | -               |
| 5           | НД           | 6                            | 193.0          | -                     | -               |
| 6           | СБД          | 32                           | 10140.5        | 9                     | 4,814.6         |
| 7           | СХД          | 7                            | 1677.7         | 6                     | 2,169.1         |
| 8           | ХУД          | 23                           | 16390.7        | 13                    | 8,433.0         |
| 9           | ЧД           | 22                           | 13543.2        | 6                     | 2,793.4         |
| <b>Нийт</b> |              | <b>153</b>                   | <b>84711.0</b> | <b>91</b>             | <b>54,339.9</b> |

Дээрх 310 ажлаас 53-д газрын зөвшөөрөл шаардлагатайгаас 3 нь зөвшөөрөлгүй байна.

<sup>7</sup> 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

**Хүснэгт 8 . Газрын зөвшөөрөлгүй ТАХ**

/сая.төг/

| Газрын зөвшөөрөл шаардагдах |              |                        | Газар чөлөөлөлт дуусаагүй |              |                        |
|-----------------------------|--------------|------------------------|---------------------------|--------------|------------------------|
| Тах-ний тоо                 | төсөвт өртөг | 2022 онд санхүүжих дүн | ТАХ-ний тоо               | Төсөвт өртөг | 2022 онд санхүүжих дүн |
| 53                          | 56,548.6     | 49,705.1               | 3                         | 1,921.5      | 1,921.5                |

Барилга байгууламжийн төлөвлөлтөд байршлын давхцал үүссэн, газаргүй ажлууд төлөвлөж баталсан байна. Үүнд:

- БЗД-т "Өглөөний гудамж" төслийн тохижилтын ажил
- Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 0.55 км авто замын ажил
- Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, 0.4 км авто замын ажил

ТАХ-г төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г тусгаж байгаа нь тогтоолоор баталсан дэд бүтэц, тохижилт зэрэг бүтээн байгуулалтын ажлууд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй, он дамжих зэрэг үр дагавар үүсэж байна.

**Дүгнэлт:** Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг төсөвтэй байх шаардлагыг хангуулаагүй нь ТАХ-ний хэрэгжилт удаашрахад нөлөөлж байна.

**В.1.2.4 Төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулсан уу?**

Дүүргүүд тухайн онд хэрэгжүүлэх 224,740.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 485 ТАХ-г батлахдаа хэрэгжих боломжит хугацаанд санхүүжилтийг тооцсон эсэхийг тодруулахад БЗД, ХУД-ийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх 6,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 100.0-1,750.0 сая төгрөгөөр дутуу баталжээ.

**Хүснэгт 9. Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ**

| №  | Төсөл арга хэмжээний нэр  | Хэрэгжих хугацаа |        | Батлагдсан   |               | Санхүүжих дүнгийн зөрүү |         |
|----|---|------------------|--------|--------------|---------------|-------------------------|---------|
|    |   | Эхлэх            | Дуусах | Төсөвт өртөг | Санхүүжих дүн | Тэнцүү хуваарилсан дүн  | Зөрүү   |
| 1. | Худалдаа үйлчилгээний гудамж, тохижилт бүхий экстрем талбайн ажил / БЗД, 10 дугаар хороо/ | 2022             | 2022   | 4,500.0      | 500.0         | 2,250.0                 | 1,750.0 |
| 2. | Наадамчдын замаас Нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэл авто замын засвар, шинэчлэлт /ХУД/     | 2022             | 2022   | 1750.0       | 750.0         | 850.0                   | 100.0   |
|    | Нийт  |                  |        | 6,250.0      | 1,250.0       | 3,100.0                 | 1,850.0 |

**Дүгнэлт:** Дүүргүүд ТАХ-г хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулжээ.

**В.1.2.5 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримталсан уу?**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 -т төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байхаар тусгасан ч 2022 онд хэрэгжиж дуусах 8,300.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 46 ТАХ-ний гэрээг 2022.10 дугаар сараас хойш байгуулсан. Үүнээс шалтгаалж ТАХ нь тухайн ондоо хийж, дуусахгүй, он дамжин хэрэгжих нөхцөл байдал үүсэж байна. Хавсралт 5

## БҮЛЭГ В2. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ ЭСЭХ

### В.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан уу?

2022 онд худалдан авахаар төлөвлөсөн нийт 139,161.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 424 ТАХ-ээс 352 ТАХ-ний ХАА зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.

#### Хүснэгт 10. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ

| № | Дүүргийн нэр | ХАА зохион байгуулсан ТАХ |                  | ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ |                   |                 |               |
|---|--------------|---------------------------|------------------|-------------------------------------|-------------------|-----------------|---------------|
|   |              | ТАХ-ны тоо                | Төсөвт өртөг     | ТАХ-ны тоо                          | Төсөвт өртөг      | Шалгарсан өртөг | Хэмнэлт       |
| 1 | БГД          | 16                        | 4950             | 16                                  | 4,950.00          | 4,715.5         | 234.5         |
| 2 | БЗД          | 79                        | 47574            | 66                                  | 40,971.90         | 40,030.1        | 941.8         |
| 3 | БНД          | 41                        | 2954.5           | 34                                  | 2,461.80          | 2,353.2         | 108.6         |
| 4 | БХД          | 23                        | 390.2            | 22                                  | 385.2             | 366.4           | 18.8          |
| 5 | НД           | 25                        | 1312.1           | 22                                  | 1,307.10          | 1,085.8         | 221.3         |
| 6 | СБД          | 79                        | 21760.664        | 65                                  | 18,076.90         | 17,825.6        | 251.3         |
| 7 | СХД          | 28                        | 9507.5           | 22                                  | 6,297.40          | 5,656.5         | 641.0         |
| 8 | ХУД          | 56                        | 37374.9          | 36                                  | 19,878.90         | 19,020.4        | 858.5         |
| 9 | ЧД           | 77                        | 13337.7          | 69                                  | 7,366.70          | 6,895.5         | 471.2         |
|   | <b>Нийт</b>  | <b>424</b>                | <b>139161.56</b> | <b>352</b>                          | <b>101,695.80</b> | <b>97,948.9</b> | <b>3746.9</b> |

2022 онд 37,465.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ дараах байдлаар хэрэгжиж дуусаагүй байна. Үүнд:

- 19,585.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 44 ТАХ он дамжин зарлагдаж байгаа;
- 17,880.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ТАХ нь зураг төсөв, ажлын даалгаваргүй тул цуцлагдсан;

Дүүргүүдийн ХАА зарласан ТАХ-ний 83%-д нь гэрээ байгуулагдсан ч 20.5%-д нь шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.

#### В. 2.1.1 Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг зарласан уу?

ДЗД-ын захирамжаар дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-г бусад төсвийн шууд захирагч нарт эрх шилжүүлээгүй байна.

#### В.2.1.2 Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан уу?

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний тендерийн баримт бичгийг боловсруулахдаа хууль, журам болон тендерийн жишиг баримт бичгийн дагуу боловсруулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Зарим дүүргийн ИТХ нь ТАХ-г батлахдаа нийт дүнгээр баталж, ЗД-ын захирамжаар задлах, тогтоолоор баталсан ТАХ-г багцлан тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулан ажилласан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 5<sup>8</sup> дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:
  - СБД нь 640.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зураг төсөв боловсруулах” ТАХ-г 21 ажил болгон задалсан бөгөөд 16 ТАХ-г тендер шалгаруулалтын онцгой журмаар шууд гэрээ байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

<sup>8</sup> 8.5.Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно

- СХД нь 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн хашаа шинэчлэх /78, 91,92, 99, 101, 112, 118, 119 дүгээр цэцэрлэг” ТАХ-г 7 багц болгон задалсан бөгөөд 3 ТАХ-г тендер шалгаруулалтын онцгой журмаар шууд гэрээ байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.
  - ЧД нь Олон улсын Аймбрик хөтөлбөрийг цэцэрлэг хэрэгжүүлэх 389.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 ТАХ-г ТШОЖ-ын шууд гэрээ байгуулах аргаар ХАА-г зохион байгуулахдаа 270.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ-г Шимт боловсрол ХХК-д, 119.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-г “Эс Жи Жи Прэнд” ХХК-д буюу 2 гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.  
Дээрх ТАХ-үүдийг газар зүйн байрлал, нэг төрлийн болон ижил төстэй байдлыг харгалзан нэгтгэж худалдан авах ажиллагааны нээлттэй тендер шалгаруулах журмыг сонгоогүй байна.
2. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.10<sup>9</sup> заасны дагуу зураг төсөл, барилга угсралт, тохируулгын ажлыг энэ хуулийн 5.1.16-д заасан журмаар түлхүүр гардуулах гэрээгээр гүйцэтгүүлэхээр бүхэлд нь тендер зарлаж болохоор зохицуулсан. Гэтэл түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй тендерийн жишиг баримт бичгийг СС-ын 2021 оны 08 сарын 31-ний өдрийн 145 дугаар тушаалаар хүчингүй болгосноос шалтгаалж зарим хүндрэл гарч байна. Тухайлбал: ХУД нь түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 3,220.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ хүчингүй болсон тендерийн баримт бичгээр боловсруулан батлуулж, ХАА-г явуулсан байна.

**Хүснэгт 11. Хүчингүй болсон тендерийн бичиг баримтаар худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ажлууд**

|      |              |  |              | /сая.төг/             |
|------|--------------|--|--------------|-----------------------|
| №    | Дүүргийн нэр | Төсөл, арга хэмжээний жагсаалт   | Төсөвт өртөг | Тендер зарласан огноо |
| 1    | ХУД-ийн ХААА | 14, 15 дугаар байрны ард талын тоглоомын талбайг шинэчлэх (1 дүгээр хороо)   | 250.0        | 2022.02.16            |
| 2    | ХУД-ийн ХААА | Хороолол дундах зам, талбай, явган хүний замын засвар, тохижилт (1, 2, 3 дугаар хороо)                             | 250.0        | 2022.02.08            |
| 3    | ХУД-ийн ХААА | Хороолол дундах зам, талбай, явган хүний замын засвар, тохижилт (19, 20 дугаар хороо)                              | 250.0        | 2022.03.22            |
| 4    | ХУД-ийн ХААА | Хороолол дундах зам, талбай, явган хүний замын засвар, тохижилт (11, 15, 17 дугаар хороо)                          | 250.0        | 2022.04.20            |
| 5    | ХУД-ийн ХААА | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвийн байрыг буулгаж, шинээр барих | 600.0        | 2022.02.11            |
| 6    | ХУД-ийн ХААА | Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /дотор засвар, сантехник, лифт (20 дугаар хороо)                           | 900.0        | 2022.03.09            |
| 7    | ХУД-ийн ХААА | Замын Цагдаагийн хэлтсийн барилгын дулаалга, фасад засвар (20 дугаар хороо)  | 220.0        | 2022.05.19            |
| 8    | ХУД-ийн ХААА | Гэрэлтүүлэг  | 500.0        | 2022.05.06            |
| Нийт |              |  | 3,220.0      |                       |

Бусад дүүргүүд түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажлуудыг нээлттэй тендер шалгаруулах тендерийн жишиг баримт бичгийн дагуу боловсруулан батлуулсан байна.

**Дүгнэлт:** Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан байна.

<sup>9</sup> 8.10.Зураг төсөл, барилга угсралт, тохируулгын ажлыг энэ хуулийн 5.1.16-д заасан журмаар түлхүүр гардуулах гэрээгээр гүйцэтгүүлэхээр бүхэлд нь тендер зарлаж болно.

### В.2.1.3 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу шалгаруулсан уу?

Дүүргийн ЗД нарын 83 удаагийн захирамжаар ХАА-г зохион байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороодыг байгуулсан.

ХАА зохион байгуулсан ТАХ-ний худалдан авалтын 46.6%-ийг нээлттэй тендер шалгаруулалт, 5.1%-ийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох, 18.2%-ийг харьцуулалт, 30.1%-ийг шууд гэрээ байгуулах журмаар тус тус зохион байгуулжээ.

**Хүснэгт 12. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам**

| №           | Дүүргийн нэр | Гүйцэтгэгч сонгон шалгарсан |                 | Нээлттэй тендер шалгаруулалт |                 | Харьцуулалтын арга |                | Шууд гэрээ байгуулах |                | Зөвлөх үйлчилгээ |              |
|-------------|--------------|-----------------------------|-----------------|------------------------------|-----------------|--------------------|----------------|----------------------|----------------|------------------|--------------|
|             |              | Тоо                         | Гэрээний үнэ    | Тоо                          | Гэрээний үнэ    | Тоо                | Гэрээний үнэ   | Тоо                  | Гэрээний үнэ   | Тоо              | Гэрээний үнэ |
| 1           | БГД          | 16                          | 4,715.5         | 13                           | 4,308.4         | 3                  | 407.1          | -                    | -              | -                | -            |
| 2           | БЗД          | 66                          | 40,030.1        | 56                           | 39,300.1        | 8                  | 530.0          | 2                    | 200.0          | -                | -            |
| 3           | БНД          | 34                          | 2,353.2         | 7                            | 1,634.8         | 3                  | 214.3          | 23                   | 354.5          | 1                | 149.6        |
| 4           | БХД          | 22                          | 366.4           | -                            | -               | 3                  | 152.6          | 16                   | 131.3          | 3                | 82.5         |
| 5           | НД           | 22                          | 1,085.8         | 5                            | 637.6           | 6                  | 251.6          | 10                   | 163.0          | 1                | 33.6         |
| 6           | СБД          | 65                          | 17,825.6        | 30                           | 16,216.7        | 15                 | 1,091.8        | 16                   | 295.0          | 4                | 222.1        |
| 7           | СХД          | 22                          | 5,656.5         | 5                            | 4,434.1         | 11                 | 1,120.1        | 6                    | 102.3          | -                | -            |
| 8           | ХУД          | 36                          | 19,020.4        | 27                           | 18,345.1        | 2                  | 135.7          | 1                    | 229.2          | 6                | 310.4        |
| 9           | ЧД           | 69                          | 6,895.5         | 21                           | 5,599.9         | 13                 | 661.1          | 32                   | 497.4          | 3                | 137.1        |
| <b>Нийт</b> |              | <b>352</b>                  | <b>97,948.9</b> | <b>164</b>                   | <b>90,476.6</b> | <b>64</b>          | <b>4,564.4</b> | <b>106</b>           | <b>1,972.7</b> | <b>18</b>        | <b>935.2</b> |

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.4<sup>10</sup>-т заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл буюу дүүргийн ЗДТГ-ын салбарын мэргэжилтнүүд, "ИТХ-аас томилсон 19 иргэнийг оролцуулсан байна.

ХАА-ны ил тод байдлыг хангах хүрээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2<sup>11</sup>-т заасны дагуу гэрээ хийгдсэн 95,976.2 төгрөгийн төсөвт өртөгтэй 246 ТАХ-г Төрийн Худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр зохион байгуулжээ.

Аудитад 2022 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгарсан 97,948.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 352 ТАХ-ээс 89,806.8 сая төгрөгийн гэрээний 190 ТАХ буюу 55.7% хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Тухайлбал: *Хавсралт 6*.

#### БГД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- Тоглоомын талбай байгуулах ажил. /2,3,12-р хороо/. Гэрээний дүн: 250.0 сая төгрөг. Гүйцэтгэгч Нутгийн их үйлс ХХК. Тендерийн үнийн санал ирүүлэхдээ ТШЗ 16 болон 23.5.3-т V бүлэгт тусгасан тендерийн жишиг маягт 1-ийг мөрдөөгүй. Мөн маягт 4-т заасан "тендерт санал болгож хүний нөөцийн мэдээлэл", маягт 5-д заасан "тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл", маягт 6-д заасан "ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл", маягт 8-д заасан "ижил төстэй гэрээний

<sup>10</sup> 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

<sup>11</sup> 21.2.Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

дэлгэрэнгүй мэдээлэл” зэргийг тус тус өөрөөр ирүүлсэн. Маягт 7-д заасан “хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийг ирүүлээгүй.

- Н.Цэрэнноровын гудамжны тохижилт. Гэрээний дүн: 200.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Веллко инк ХХК. ТШЗ 17.6.5.8-д зааснаар ТШЗ-д “шаардсан материалуудын аль нээ ирүүлээгүй, эсхүл өөрөөр ирүүлсэн тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно”. ТШЗ 23.5.3 ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан “V бүлгийн тендерийн жишиг маягуудын Маягт 8 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл”-үүдийг тус тус өөрөөр ирүүлсэн. Маягт 7-д заасан “хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийг ирүүлээгүй.
- Түшиц хана засварлах ажил 19-р хороо /гэр хорооллын нүхэн жорлонг сайжруулах/ Гэрээний дүн: 436.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Энх бизнес өгөөмж ХХК. ТШЗ 23.5.3 ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан “V бүлгийн тендерийн жишиг маягуудын Маягт 4 Тендерт санал болгож хүний нөөцийн мэдээлэл”, Маягт 5 “Тендерийн санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл”, Маягт 8-д заасан “Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл”-үүдийг тус тус өөрөөр ирүүлсэн. Маягт 7-д заасан “хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийг ирүүлээгүй байхад шалгаруулсан.

### **БЗД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:**

- Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо, 1,3 км авто замын ажил. Гэрээний дүн: 397.8 сая төгрөг. Гүйцэтгэгч Нью процесс ХХК. ТШЗ 22.6-д тендерийн баталгааг ирүүлэхдээ “Голомт банкны 2022.05.04-ны өдрийн 10/228 тоот албан бичгээр хүчинтэй хугацааг 2022.06.15-ны өдөр хүртэл байхаар буюу 38 хоногоор буюу 20 хоногоор дутуу” ирүүлсэн.
- Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо, 1,3 км авто замын ажил. Гэрээний дүн: 1,989.0 сая төгрөг. Гүйцэтгэгч Пи си эф ХХК. ТШЗ 16.2-д заасан “Шүүхийн тусгай архивын лавлагаагаар МЧХ ХХК 40.2 сая, Б.Булгантамир 26.1 сая, Сэлэнгэ АЗЗА ТӨХК 76.8 сая, Түшиг даян оргил ХХК 11.5 сая төгрөгийг Пи си эф ХХК-ээс төлбөр гаргуулах нэхэмжлэл гаргасан. Пи си эф ХХК нь шүүхэд хариуцагчаар татагдсан”. “Хариуцагч нь төлбөр төлсөн нотлох баримт” ирүүлээгүй. ТШЗ 17.6.3.1-д заасан “Гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай машин механизмуудын 50-аас доошгүй хувь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийнх байх шаардлагатай гэсэн заалтуудыг үндэслэж тулган баталгаажуулаагүй”.
- Баянзүрх дүүргийн Засаг даргын харьяа газар, хэлтэс, албадад тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил. Гэрээний дүн: 400.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Саммит ХХК. ТӨХ-ийн ТШЗ 17.1-д заасан “Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, ер төлбөргүй байх шаардлагатай” гэснийг зөрчин 0.03 сая төгрөгийн татварын өртэй компани шалгаруулсан.

### **СХД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:**

- Гэрлэх ёслолын өргөөний тохижилтын ажил. Гэрээний дүн: 224.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Өндөрхаан өргөө ХХК. ТШЗ 12.1, 12.2-д тендерийн бүх бичиг баримт монгол хэл дээр ирүүлнэ гэж заасан ч “Өндөрхаан өргөө ХХК нь иргэн Б.Мандарваагийн зарим баримт бичгийн орчуулгыг гадаад хэлээс орчуулан” ирүүлээгүй. ТШЗ 17.8-д зааснаар “Өндөрхаан өргөө ХХК -ийн гэрээний үнэ нь 224.9 сая төгрөг бөгөөд Уянгын гурван эрдэнэ ХХК-тай 25.5 сая төгрөгийн туслан гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан. Энэ гэрээний үнийн дүнгийн 11.3 хувиар Уянгын гурван эрдэнэ ХХК-тай гэрээ байгуулсан нь ТШЗ 17.8. заалтыг зөрчсөн.
- Техник тоног төхөөрөмж худалдан авах /гэр хорооллын нүхэн жорлонг сайжруулах/. Гэрээний дүн: 820.0 сая төгрөг. Гүйцэтгэгч Ган бүрэн ХХК. ТШЗ 13.1, 13.2-т: “Тендерийн бүх бичиг баримтыг Монгол хэл дээр ирүүлнэ гэж заасан ч Ган бүрэн ХХК нь тухайн бараа худалдан авсан гэрээ болон зарим сертификат бусад баримт бичгийн орчуулгыг гадаад хэлээс орчуулан” ирүүлээгүй. ТШЗ 24.5.3. 9-т “Техникийн

тодорхойлолт дээр 2022 оноос хойш орж ирсэн гаалийн бичигтэй гэж заасан ч 2021 оны 09 сарын 09 өдөр орж ирсэн ачааны машин” авсан. ТШЗ 24.5.3 ТШЗ-ны “16 дугаар зүйлд заасан “V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 6 хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийг ирүүлээгүй.

- Техник тоног төхөөрөмж худалдан авах /гэр хорооллын нүхэн жорлонг сайжруулах / Гэрээний дүн: 500.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Ган бүрэн ХХК. ТШЗ 13.1, 13.2-д заасан “тендерийн бүх бичиг баримт монгол хэл дээр ирүүлнэ” гэж заасан ч Ган бүрэн ХХК нь тухайн бараа худалдан авсан гэрээ болон сертификат бусад баримт бичгийн орчуулгыг гадаад хэлээс орчуулан ирүүлээгүй. ТШЗ 24.5.3 ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан “V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 6 хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийг ирүүлээгүй.

#### **ЧД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ажил:**

- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх. Гэрээний дүн: 166.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Би Жи Роял ХХК. ТШЗ 18.6.8.5-д заасан “Нийлүүлэх тоног төхөөрөмжийн каталог ирүүлсэн боловч ТШЗ 13.1 зааснаар тоног төхөөрөмжийн каталогийг орчуулга хийлгээгүй”. ТШЗ 18.7-д заасан “хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийг ирүүлээгүй.
- 1-6 дугаар хороо фасад засвар Багц 1 Гэрээний дүн: 219.1 сая төгрөг. Гүйцэтгэгч: Ирмүүн бар ХХК ТШЗ 17.6 заасан “гэрээ ирүүлсэн ч маягтын дагуу” ирүүлээгүй. Мөн 2020 онд Франц улсын элчин сайдын яамтай байгуулсан гэрээ нь орчуулга байхгүй.
- 1-6 дугаар хороо фасад засвар Багц 2 Гэрээний дүн: 234.8 сая төгрөг. Гүйцэтгэгч: Шинэ өлгийн зам ХХК. ТШЗ 17.6.4 Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: “Шаардлагатай” 2020, 2021 оны ижил төстэй ажлын жагсаалтыг тендерийн баримт бичгийн 5 дугаар бүлгийн 6,7,8 дугаар маягтын дагуу ирүүлнэ гэж заасан боловч Маягт 7 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл, Маягт 8 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй.

Аудитад хамрагдсан 190 ТАХ-ний тендерийн баримт бичиг, гүйцэтгэгчээс ирүүлсэн баримт, материалыг шалгуур үзүүлэлттэй тулган шалгахад 13,417.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дээрх 32 ТАХ-нд шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3 “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэсэн заалтыг зөрчжээ.

Дээрхээс гадна ТАХ-ний ХАА-г зохион байгуулахад БЗД, ХУД-ийн ХААА-ны дотоод аудиторуд нийт 140,095.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ТАХ-ний ҮХ-нд ажилласан байна. Дотоод аудиторын ажлын байрны тодорхойлолтод зааснаар албаны дотоод үйл ажиллагаанд хяналт тавихаар заажээ.

Мөн БГД-ийн ЗД-ын захирамжаар байгуулсан бүх үнэлгээний хороонд нэр бүхий 2 иргэн хөндлөнгийн гишүүнээр оролцсон байна. Иймд иргэд болон мэргэжлийн холбоодын төлөөллийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Цаашид илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг үнэн зөвөөр үнэлэх, шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

**Дүгнэлт:** ХАА-г зохион байгуулахдаа ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна. Гүйцэтгэгч сонгон шалгарсан 97,948.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 352 ТАХ-ээс 12,782.3 сая төгрөгийн дүнтэй 29 ТАХ буюу 8.2 %- нь ТББ болон ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй байна.

## В.2.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй байна уу?

Дүүргүүдийн хэмжээнд 171,082.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 518 ТАХ хэрэгжиж байгаагаас 2022 онд 61,066.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 355 ТАХ хэрэгжиж дууссан байна.

**Хүснэгт 13. 2022 онд хэрэгжсэн, он дамжсан, хэрэгжээгүй ТАХ**

| №    | Дүүргийн нэр | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | гэрээний дүн | Хэрэгжиж дууссан ажил |          | Он дамжин хэрэгжиж байгаа |          | /сая.төг/ Хэрэгжээгүй |          |
|------|--------------|-------------|--------------|--------------|-----------------------|----------|---------------------------|----------|-----------------------|----------|
|      |              |             |              |              | тоо                   | дүн      | тоо                       | дүн      | тоо                   | дүн      |
| 1    | БГД          | 59          | 20,033.4     | 17,236.5     | 50                    | 10,926.4 | 4                         | 575.2    | 5                     | 5,734.9  |
| 2    | БЗД          | 65          | 39,126.6     | 38,977.8     | 26                    | 15,110.4 | 23                        | 14,090.3 | 16                    | 9,777.1  |
| 3    | БНД          | 55          | 3,044.9      | 2,988.7      | 41                    | 1,724.8  | 9                         | 860.5    | 5                     | 403.5    |
| 4    | БХД          | 22          | 385.2        | 366.4        | 22                    | 366.3    | -                         | -        | -                     | -        |
| 5    | НД           | 24          | 1,307.1      | 1,254.9      | 23                    | 1,175.1  | 1                         | 79.8     | -                     | -        |
| 6    | СБД          | 83          | 36,908.8     | 36,673.6     | 69                    | 7,933.7  | 12                        | 28,135.3 | 2                     | 604.7    |
| 7    | СХД          | 30          | 7,439.1      | 6,230.8      | 26                    | 4,478.8  | 4                         | 1,752.0  | -                     | -        |
| 8    | ХУД          | 93          | 51,078.0     | 47,549.6     | 46                    | 14,463.2 | 35                        | 33,086.4 | 12                    | -        |
| 9    | ЧД           | 87          | 11,759.0     | 10,309.4     | 52                    | 4,887.8  | 4                         | 2,166.9  | 31                    | 3,254.7  |
| Нийт |              | 518         | 171,082.1    | 161,587.7    | 355                   | 61,066.5 | 92                        | 80,746.4 | 71                    | 19,774.9 |

Харин 80,746.4 төгрөгийн дүнтэй 92 ТАХ 0-95%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байгаа, 19,774.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 71 ТАХ тухайн онд хэрэгжиж эхлээгүй байна. Эдгээр ТАХ-ны шалтгааныг тодруулахад дараах байдалтай байна.

Үүнд:

- СБД-т “Ахмадын хөгжлийн барилгын ажил” гэрээний дүн 870.2 сая төгрөг. Гүйцэтгэгч: Аяа ХХК Ажлын гүйцэтгэл: 90%, 2022 онд 754.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Гэрээний хугацаа 2022.09.20-нд дууссан. Тус барилгын бохирын шугамыг Ус Сувгийн Удирдах Газраас олгосон техникийн нөхцөлийн дагуу ф500 шугамд холбох боломжгүй болсон тул өөр газарт шилжүүлэх шинэ техникийн нөхцөл авсан, ажил гүйцэтгэх хугацаа нь улирлын заалттай тул гэрээ сунгах шаардлагатай.
- СБД-т “7 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв, цагдаа, хорооны ажлын албаны нэг цэгийн үйлчилгээний байр шинээр барих” ажил “ТЭТҮ” ХХК нь байгуулсан гэрээний хүрээнд ажлыг үргэлжлүүлэхэд шүүхийн маргаантай холбоотой асуудлаас болж 2015 оноос хойш барилгын ажил зогсонги байдалтай байна.
- БЗД-т Баянзүрх дүүргийн 1, 5, 6, 7, 9, 13, 15, 17, 20, 25 дугаар хороодод явган зам, талбайн шинэчлэлтийн ажил. Гэрээний дүн 226.1 сая төгрөг. Гүйцэтгэгч: Хөрөнгийн бэл ХХК Ажлын гүйцэтгэл: 42%, Тус төсөл арга хэмжээний ажлын даалгавар Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээтэй давхцсан.
- Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо, 0.51 км авто замын ажил. Гэрээний дүн 750.3 сая төгрөг. Гүйцэтгэгч: Шинэ цагийн зам ХХК Ажлын гүйцэтгэл: 80%, 599.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Батлагдсан зураг төсвийн дагуу барилга угсралтын ажлын явцад газар чөлөөлөлтийн ажлууд удааширсан.
- Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 0.55 км авто замын ажил. Барилга байгууламжийн төлөвлөлтөд байршлын давхцал үүссэн учир ажил эхлээгүй.
- БГД-т “Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар, хороодын тохижилт” Хүйтний улирал эхэлсэн, он дамжиж байгаа
- Цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын зураг, төсөв /Баянгол Агропарк ОНӨТҮГ/ Гэрээний дүн 119.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Нью-синдкат ХХК. Ажлын гүйцэтгэл: 70%,

- 71.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Зураг төсвийн магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй, он дамжиж байгаа
- ЧД-т Хорооны цогцолбор барилга. Ажлын даалгавар бэлэн болоогүй учир тендер зарлаагүй.

Аудитад 2022 онд хэрэгжиж дууссан 61,066.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 355 ТАХ-ны төрөл бүрээс түүвэрлэн 45,627.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 179 ТАХ-г хамруулан газар дээр нь шалгаж тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

БГД-ийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, “Сэтгэшгүй нэмэх”ХХК-аас хяналт тавьсан 9,306.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 30 ТАХ-г шалгахад 2 зөрчил илэрсэн.

- Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлт. Гэрээний дүн:762.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: Гоц тэх инженеринг ХХК. Мод тойруулж хийсэн эко хавтангийн хашлага эвдэрсэн.
- Явган хүний зам 7, 8, 12-15, 17, 18, 19 дүгээр хороо /нийтийн эзэмшлийн зам талбайд/ Гэрээний дүн:419.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Бумбат даваа ХХК. Явган замын олсон хашлагийн 4 шон эвдэрсэн.

БЗД-ын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, НЗХГ-ын хяналт тавьсан 10,900.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 20 ТАХ-г бүрэн хамруулахад 3 ТАХ-нд зөрчил илэрсэн.

- Баянзүрх дүүргийн хороодод тохижилт, бүтээн байгуулалт, засвар, судалгааны ажил Багц-1 тохижилтын ажил. Гэрээний дүн:540.0 сая төгрөг Гүйцэтгэгч: “Голден ийгл стар”ХХК 14 дүгээр сургуулийн хөл бөмбөгийн талбайны хашаа эвдрэлтэй, хаалгачийн тор урагдсан, ашиглагч байгууллага хүлээж аваагүй байхад эвдэрсэн.
- Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 0.60 км авто замын ажил. Гэрээний дүн: 910.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Нано экологи”ХХК газар чөлөөлөлт бүрэн дуусаагүй, гүйцэтгэл дутуу санхүүжилтийг 100 хувь олгосон. Газрын маргаантай хэсгийн ажлыг гүйцэтгээгүй, ажлын гүйцэтгэл бүрэн тооцоогүй, санхүүжилт бүрэн авсан.
- Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо, 1.033 км авто замын ажил. Гэрээний дүн:1,561.4 сая төгрөг. Гүйцэтгэгч: БСМ ХХК. Газар чөлөөлөлт бүрэн дуусаагүй гүйцэтгэл дутуу санхүүжилтийг бүрэн олгосон.

СБД-ын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн хяналт тавьсан 3,202.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 25 ТАХ-г түүвэрлэн үзэхэд 2 ТАХ-нд зөрчил илэрсэн.

- 9 дүгээр хороо, Алтайн гудамж дагуу Хоймор оффисоос урагшаа уулзвар хүртэл явган хүний зам. Гэрээний дүн: 170.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: “ВИЛЛА БРИДЖ” ХХК. Явган хүний зам эвдрэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглүүлэгч эхлэл, төгсгөлийн хавтан эвдрэлттэй, 1ш сандал эвдэрсэн, суурилуулсан 3ш хогийн сав байхгүй.
- 11 дүгээр хороо, Хангай хотхоны 504, 514 дүгээр байрны дунд тохижилт. Гэрээний дүн: 250.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: ЭМ БИ ЭМ ТИ ЭМ КОНСТРАШН” ХХК. Явган хүний замын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглүүлэгч хавтангийн эхлэл, төгсгөлийн хавтан байхгүй, өөр хавтангаар хийсэн.

СХД-ийн “Захиалагчийн алба”ОНӨААТҮГ-ын хяналт тавьсан 5,167.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 20 ТАХ-г түүвэрлэн үзэхэд 2 ТАХ-нд зөрчил илэрсэн.

- Нэгдсэн эмнэлэгт хөшиг суурилуулах. Гэрээний дүн: 62.1 сая төгрөг. Гүйцэтгэгч: Алтангэрэл шим ХХК. Гал тогооны өрөөнд суурилуулсан 5 ширхэг цонхны хөшиг эвдэрсэн.
- Хог тээврийн авто машин худалдан авах Гэрээний дүн: 922.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Трансвайд Солюшн ХХК. КАМАЗ маркын 65-21 УЕК улсын дугаартай

Дүүргийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

автомашин цахилгааны масстай. Баталгаат засварын хугацаанд гүйцэтгэгчээр засуулахаар ажиллаж байна.

Иймд эвдэрсэн болон дутуу ажлыг чанарын баталгаат хугацаанд нь дахин хийлгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, шуурхай арилган эргэн мэдэгдэх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

**Дүгнэлт:** Аудитын түүвэрт хамрагдсан 45,627.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 179 ТАХ-ээс 40,028.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 170 ТАХ буюу 95.0 %-д нь захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

### В.2.3. Санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон уу?

ДИТХ-аас баталсан тогтоолд дүүргүүдийн хэмжээнд он дамжих болон шинээр хэрэгжих 485 ТАХ-нд 2022 онд нийт 180,395.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 104,768.1 сая төгрөг олгосон байна. 2022 онд хэрэгжиж дууссан 355 ТАХ-нээс 51,337.6 сая төгрөгийн өртөг бүхий 255 ТАХ-г хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна.

#### В.2.3.1. Санхүүжилтийг төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үндэслэн, холбогдох журам, гэрээнд заасан хугацаанд олгосон уу?

Дүүргүүдийн төсвийн хөрөнгөөр шинэ болон шилжих 485 ТАХ-нд 2022 онд 180,395.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 411 ТАХ 104,768.1 сая төгрөг буюу 58.1 хувийн санхүүжилт олгожээ.

Харин он дамжин санхүүжих 175 ТАХ-нд тухайн онд санхүүжих 51,809.4 сая төгрөгийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 39,825.4 сая төгрөг буюу 76.8%-ийн санхүүжилт олгожээ.

#### Хүснэгт 14. ТАХ-ний санхүүжилтийн судалгаа

| № | Дүүргийн дүн | Өмнөх оноос хэрэгжсэн |          |            |          | 2022 онд шинээр хэрэгжсэн |           |            |          | Нийт      |           |            |           |
|---|--------------|-----------------------|----------|------------|----------|---------------------------|-----------|------------|----------|-----------|-----------|------------|-----------|
|   |              | Санхүүжих             |          | Санхүүжсэн |          | Санхүүжих                 |           | Санхүүжсэн |          | Санхүүжих |           | Санхүүжсэн |           |
|   |              | Тоо                   | Дүн      | Тоо        | Дүн      | Тоо                       | Дүн       | Тоо        | Дүн      | Тоо       | Дүн       | Тоо        | Дүн       |
| 1 | БГД          | 43                    | 6,341.1  | 38         | 5,859.5  | 16                        | 4,950.0   | 16         | 4,615.4  | 59        | 11,291.1  | 54         | 10,474.9  |
| 2 | БЗД          | 6                     | 3,582.9  | 3          | 3,279.5  | 64                        | 48,926.2  | 46         | 20,498.1 | 70        | 52,509.1  | 49         | 23,777.6  |
| 3 | БНД          | 21                    | 648.4    | 17         | 416.5    | 38                        | 2,869.3   | 26         | 1,335.2  | 59        | 3,517.7   | 43         | 1,751.7   |
| 4 | БХД          | -                     | -        | -          | -        | 11                        | 390.2     | 22         | 351.3    | 11        | 390.2     | 22         | 351.3     |
| 5 | НД           | 2                     | 170.0    | 2          | 89.3     | 23                        | 1,142.1   | 23         | 1,052.2  | 25        | 1,312.1   | 25         | 1,141.5   |
| 6 | СБД          | 21                    | 15,263.4 | 14         | 9,733.7  | 38                        | 16,588.8  | 57         | 9,773.6  | 59        | 31,852.2  | 71         | 19,507.3  |
| 7 | СХД          | 10                    | 2,138.4  | 13         | 1,697.4  | 18                        | 8,614.2   | 17         | 4,479.2  | 28        | 10,752.6  | 30         | 6,176.6   |
| 8 | ХУД          | 30                    | 14,894.7 | 25         | 10,818.9 | 43                        | 26,094.5  | 33         | 15,491.5 | 73        | 40,989.2  | 58         | 26,310.4  |
| 9 | ЧД           | 42                    | 8,770.5  | 38         | 7,930.6  | 59                        | 19,010.5  | 21         | 7,346.2  | 101       | 27,781.0  | 59         | 15,276.8  |
|   | Нийт         | 175                   | 51,809.4 | 150        | 39,825.4 | 310                       | 128,585.8 | 261        | 64,942.7 | 485       | 180,395.2 | 411        | 104,768.1 |

Нийт олгосон 104,768.1 сая төгрөгийн санхүүжилтээс 1,449.3 сая төгрөгийг дүүргүүд техник хяналтын зардал болон зураг төсөв, магадалшгүй ажил, зохиогчийн хяналтын зардалд зарцуулсан.

Аудитаар 9 дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтсээс санхүүжилт олгосон дансны хуулгыг гэрээний хэрэгжилттэй холбоотой баримтууд /гэрээ дүгнэсэн протокол, ажлын гүйцэтгэл, ажил хүлээлцсэн актууд/-тай тулган шалгахад олгосон нийт санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд нь үндэслэн олгожээ.

Хэрэгжиж дууссан ТАХ-ний барьцаанд 2,984.8 сая төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж, гэрээний үүргээ зөрчсөн 42 гүйцэтгэгчээс гэрээний хугацаа хэтрүүлсэн алдангид 110.0 сая төгрөг суутган тооцож дүүргийн төрийн сангийн дансанд байршуулжээ.

БНД нь ТАХ-үүдийн барьцааг авахдаа ТАХ тус бүрээр бус нийт дүнгээр нь барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн. ЧД нь "Нүнжиг" ХХК-д гэрээний хугацаа хэтрүүлсэнд 0.6 сая төгрөгийн алдангид тооцсон ч санхүүжилтийг олгохдоо суутгаагүй шилжүүлсэн байна.

#### Хүснэгт 15. 2022 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги

| № | Дүүргийн нэр | Батлагдсан төсөвт өртөг |           | Олгогдсон санхүүжилт |           | Барьцаанд |         | Алданги |       |
|---|--------------|-------------------------|-----------|----------------------|-----------|-----------|---------|---------|-------|
|   |              | Тоо                     | Дүн       | Тоо                  | Дүн       | Тоо       | Дүн     | Тоо     | Дүн   |
| 1 | БГД          | 59                      | 12,851.1  | 54                   | 10,474.9  | 43        | 520.4   | -       | -     |
| 2 | БЗД          | 70                      | 56,509.1  | 49                   | 23,777.6  | 28        | 854.8   | 1       | 0.3   |
| 3 | БНД          | 59                      | 3,517.7   | 43                   | 1,751.7   | 10        | 55.8    | 1       | 3.9   |
| 4 | БХД          | 11                      | 390.2     | 22                   | 351.3     | 16        | 24.3    | 7       | 0.6   |
| 5 | НД           | 25                      | 1,312.1   | 25                   | 1,141.5   | 22        | 69.8    | -       | -     |
| 6 | СБД          | 59                      | 40,841.8  | 71                   | 19,507.3  | 50        | 452.1   | -       | -     |
| 7 | СХД          | 28                      | 13,379.5  | 30                   | 6,176.6   | 22        | 264.4   | 6       | 3.8   |
| 8 | ХУД          | 73                      | 59,922.4  | 58                   | 26,310.4  | 27        | 526.5   | 14      | 31.0  |
| 9 | ЧД           | 101                     | 36,016.3  | 59                   | 15,276.8  | 40        | 216.8   | 13      | 70.4  |
|   | Нийт         | 485                     | 224,740.2 | 411                  | 104,768.1 | 258       | 2,984.9 | 42      | 110.0 |

**Дүгнэлт:** Санхүүжилтийг төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үндэслэн, гэрээнд заасан хугацаанд олгосон байна.

### В.2.3.2 Нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан уу? Нэмэлт гэрээ нь хуульд нийцсэн үү?

Дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-нд дараах 2 дүүрэг 9 ТАХ-нд нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан байна.

#### Хүснэгт 16. Магадлал, тодотголоор нэмэгдсэн санхүүжилтийн дүн

| №           | Дүүр-гийн нэр | Төсөл, арга хэмжээний жагсаалт   | Төсөвт өртөг /2021 он/ | Эхний гэрээний дүн | Магадлал, тогтоолын огноо | Магадлал, тогтоолоор батлагдсан дүн | Сүүлийн хийсэн гэрээний дүн | Магадлал эхний гэрээний зөрүү | (сая.төг)                                |
|-------------|---------------|--|------------------------|--------------------|---------------------------|-------------------------------------|-----------------------------|-------------------------------|--|
|             |               |  |                        |                    |                           |                                     |                             |                               | Магадлал сүүлийн хийгдсэн гэрээний зөрүү |
| 1           | ХУД           | Цэцэрлэгийн барилга 200 ор /4-р хороо/   | 2400.0                 | 2,279.9            | 2022.10.11                | 3105.3                              | 2985.2                      | 825.40                        | 120.1                                    |
| 2           | ХУД           | Цэцэрлэгийн барилга 200 ор /15-р хороо/  | 2400.0                 | 2,265.3            | 2022.08.24                | 3946.5                              | 3759.9                      | 1,681.20                      | 186.6                                    |
| 3           | ХУД           | Цэцэрлэгийн барилга 200 ор /16-р хороо/  | 2400.0                 | 2,363.4            | 2022.08.24                | 3438.2                              | 3370.5                      | 1,074.80                      | 67.7                                     |
| 4           | ХУД           | Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих                                 | 2000.0                 | 1,798.7            | 2022.04.22                | 3155.1                              | 2953.8                      | 1,356.40                      | 201.3                                    |
| 5           | ХУД           | Хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга /15-р хороо/                | 2600.0                 | 2,578.1            | 2022.10.03                | 3377.8                              | 3182.3                      | 799.70                        | 195.5                                    |
| 6           | ХУД           | Хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга /21-р хороо/                | 2200.0                 | 2,164.8            | 2022.10.21                | 3307                                | 3238.6                      | 1,142.20                      | 68.4                                     |
| 7           | ХУД           | Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн камержуулалт | 300.0                  | 282.9              | 2022.07.08                | 498.1                               | 451.1                       | 215.20                        | 47.0                                     |
| 8           | ХУД           | Зам цэвэрлэгээ, усалгааны машин худалдан авах                                    | 640.0                  | 614.9              | 2022.05.31                | 737.4                               | 694.1                       | 122.50                        | 43.3                                     |
| 9           | ЧД            | Хороодын сантехник, цахилгаан, бусад засварын ажил                               |                        | 76.0               |                           | 89.1                                | 89.1                        | 13.10                         | 0  |
| <b>Нийт</b> |               |  | <b>14940.0</b>         | <b>14,424.0</b>    |                           | <b>21654.5</b>                      | <b>20724.6</b>              | <b>7,230.5</b>                | <b>929.9</b>                             |

Дээрх хүснэгтээс харахад эхний байгуулсан гэрээний дүнгээс магадлалаар батлагдсан төсөвт өртгийн дүн нь 7,230.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Харин сүүлд хийсэн гэрээний дүн магадлалаар батлагдсан дүнгээс 929.1 сая бага байна. Зураг төсөвгүй ажил ДИТХ-аар батлуулсны улмаас түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ХАА зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулснаас үүдэн үнийн өсөлттэй холбоотойгоор магадлалаар орсон төсөвт өртөг нэмэгдсэн байна. Мөн хил гааль, тээвэрлэлтийн удаашралтай байдал, валютын ханшийн өөрчлөлт зэргээс шалтгаалсан байна.

**Дүгнэлт:** Зарим дүүрэгт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-нд нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан байна.

## **В.2.4 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?**

Дүүргүүдэд өмнөх оноос дамжин хийгдсэн болон 2022 онд шинээр эхэлсэн 61,066.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 355 ТАХ-нд дүүргүүдийн ЗДТГ болон “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, “Хүн төвтэй хот төлөвлөлтийн лаборатори” НҮТББ, “Сэтгэшгүй нэмэх”ХХК, “Захиалагчийн алба”ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд гэрээгээр захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

### **В.2.4.1 Захиалагч, мэргэжлийн байгууллага үе шатны хяналтыг цаг хугацаанд нь, үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?**

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”ийн 3.9<sup>12</sup>-д заасны дагуу захиалагч нь үе шатны ажилд хяналт хэрэгжүүлэхдээ холбогдох ил далд ажлын акт, холбогдох баримт материалыг, графикт хугацаа, гэрээний дагуу хянаж баталгаажуулсан эсэхийг түүвэрлэн шалгасан.

Захиалагчаас ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахдаа ил далд ажлын актууд, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэлүүд, холбогдох бусад баримт бичгийг үндэслэж байна. ТАХ-ний хүрээнд давхардсан тоогоор туршилт тохируулга хийсэн болон ил далд ажлын 146 төрлийн 179 актыг холбогдох албан тушаалтнууд баталгаажуулжээ.

**Хүснэгт 17. Гүйцэтгэлийн шатанд баталгаажуулсан актууд**

| Туршилт тохируулга хийсэн акт |     | Далд ажлын актууд |     | Ил ажлын актууд |     |
|-------------------------------|-----|-------------------|-----|-----------------|-----|
|                               |     | Төрөл             | Тоо | Төрөл           | Тоо |
| Төрөл                         | Тоо | Төрөл             | Тоо | Төрөл           | Тоо |
| 25                            | 30  | 31                | 42  | 90              | 107 |

Дээрх байдлаар ажил гүйцэтгэх явцад үе шатны ажлын технологийн дарааллын дагуу холбогдох баримт бичиг, барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, санхүүжилт зэргийг тухай бүр хянан баталгаажуулдаг байна.

**Дүгнэлт:** Барилга байгууламж, авто зам, засварын үе шатны ажлын ил далд актууд болон туршлага тохируулга хийсэн актыг хянан баталгаажуулсан байна.

### **В.2.4.2 Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?**

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл нь холбогдох хууль журамтай нийцэж буй эсэхэд 2022 онд Дүүргүүдийн дотоод аудитын албанаас хяналт хэрэгжүүлсэн эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна.

Үүнд:

- БГД-ийн Дотоод аудитын алба нь 2022 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын худалдан авах, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналтыг хийж хэрэгжүүлсэн. Дотоод аудит, хяналт шалгалтаар хөрөнгө

<sup>12</sup> 3.9.Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 8 асуудалд зөвлөмжийг холбогдох хэлтсүүдэд өгч ажилласан байна.

- СХД-ийн Дотоод аудитын алба нь 2022 оны эхний 8 сарын байдлаар дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын худалдан авах, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналтыг хийж хэрэгжүүлсэн. Дотоод аудит, хяналт шалгалтаар хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудалд 6 зөвлөмжийг холбогдох хэлтсүүдэд өгч ажилласан байна.
- БНД, ХУД-ийн Дотоод аудитын алба нь 2022 оны жилийн төлөвлөгөөндөө дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын ажилд дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан боловч, СЯ-ны нэгдсэн удирдамжтай хяналт шалгалттай давхацсаны улмаас хийгдээгүй тайлбарыг өгч байна.
- БЗД, БХД, НД, СБД, ЧД-ийн Дотоодын аудитын алба нь жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Цаашид дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэлд дотоод хяналтыг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж үр дүн, үр нөлөөг тооцож ажиллах шаардлагатай байна.

**Дүгнэлт:** Дүүргүүд хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ТАХ-нд дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

## В.2.5 Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

2022 онд 61,066.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 355 ТАХ бүрэн хэрэгжиж дууссан. Аудитад хамрагдсан 9 дүүргийн хэмжээнд хэрэгжиж дууссан ТАХ-нээс 51,337.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 255 ТАХ хөрөнгөд бүртгэсэн, 5,006.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 72 ТАХ-г шууд зардалд тусгасан, 4,722.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 28 ТАХ-г буюу 7.8 % хувьд баримт бичгийн бүрдүүлбэрийг хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах, тогтоол гаргах зэргээр 2023 онд бүртгэгдэхээр байна.

**Хүснэгт 18. Хэрэгжсэн ТАХ-ээс бүртгэлд тусгасан байдал**

| №           | Дүүргийн нэр | Хөрөнгөнд бүртгэх ТАХ |                 | Бүртгэсэн ТАХ |                 | Шууд зардалд тусгасан |                | Бүртгээгүй ТАХ |               |
|-------------|--------------|-----------------------|-----------------|---------------|-----------------|-----------------------|----------------|----------------|---------------|
|             |              | Тоо                   | Гэрээний дүн    | Тоо           | Дүн             | Тоо                   | Дүн            | Тоо            | Дүн           |
| 1           | БГД          | 50                    | 10,926.4        | 43            | 8,508.8         | 7                     | 2,417.6        | 0              | 0.0           |
| 2           | БЗД          | 26                    | 15,110.4        | 19            | 13,745.9        | 4                     | 459.6          | 3              | 904.9         |
| 3           | БНД          | 41                    | 1,724.8         | 25            | 1,330.0         | 16                    | 394.8          | 0              | 0.0           |
| 4           | БХД          | 22                    | 366.3           | 10            | 230.6           | 0                     | 0.0            | 12             | 135.7         |
| 5           | НД           | 23                    | 1,175.1         | 12            | 896.4           | 6                     | 187.5          | 5              | 91.2          |
| 6           | СБД          | 69                    | 7,933.7         | 44            | 7,120.0         | 25                    | 813.8          | 0              | 0.0           |
| 7           | СХД          | 26                    | 4,478.8         | 14            | 1,693.1         | 8                     | 272.8          | 4              | 2512.9        |
| 8           | ХУД          | 46                    | 14,463.2        | 46            | 14,463.2        | 0                     | 0.0            | 0              | 0.0           |
| 9           | ЧД           | 52                    | 4,887.8         | 42            | 3,349.6         | 6                     | 460.4          | 4              | 1077.7        |
| <b>Нийт</b> |              | <b>355</b>            | <b>61,066.5</b> | <b>255</b>    | <b>51,337.6</b> | <b>72</b>             | <b>5,006.5</b> | <b>28</b>      | <b>4722.4</b> |

Үүнээс 2022 онд 51,337.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 255 хөрөнгийг бүртгэсэн байна. Харин 5,006.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 72 ажлыг шууд зардалд тусгаж тайлагнажээ.

Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалтын байдалтай газар дээр нь танилцахад бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломжгүй зарим зөрчил илэрч байна. Тухайлбал:

- СБД-т хэрэгжсэн “Дүүргийн шинээр баригдаж байгаа нэгдсэн эмнэлгийн материаллаг бааз бэхжүүлэх Багц2-Гал тогоо”. Гэрээний дүн: 289.8 сая төгрөг. Дүүргийн эмнэлгийн барилгын гүйцэтгэл 85% буюу эмнэлэг ашиглалтад ороогүй байхад 1,2-р хоолны тогоо, жигнүүр, усны шүүлтүүр, зуух, угаалтуур, тавиур зэрэг 51 төрлийн тоног төхөөрөмж худалдан авч ашиглалтгүй нийлүүлэгчийн агуулахад хадгалагдаж байна.
- СБД-т хэрэгжсэн “Дүүргийн шинээр баригдаж байгаа нэгдсэн эмнэлгийн материаллаг бааз бэхжүүлэх Багц1-Угаалтуур”. Гэрээний дүн: 189.3 сая төгрөг. Дүүргийн эмнэлгийн барилгын гүйцэтгэл 85% буюу эмнэлэг ашиглалтад ороогүй байхад ТАХ-ний үр дүнд бий болсон угаагч, хатаагч, уурын индүү зэрэг хөрөнгө ашиглалтгүй байна.
- БЗД-т хэрэгжсэн “Коронавируст халдвар /Ковид-19/-ын дараах эмчилгээ, сувилгааг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлэх Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын өргөтгөлийн барилгын ажил, тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил Багц-2 Шижир амралт, цогцолборын тоног төхөөрөмж” Гэрээний дүн: 250 сая төгрөг. Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын өргөтгөлийн барилгын ажил дуусаагүй, тус байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан эмчилгээ сувилгаа, чийрэгжүүлэлтийн зориулалттай эмийн хөргөгч, хаш чулуун ор, татлагын ор, налуу жийлтийн төхөөрөмж, гантел зэрэг нийт 57 төрлийн тоног төхөөрөмж ашиглалтгүй байна.
- БЗД-т хэрэгжсэн “Баянзүрх дүүргийн хороодод тохижилт, бүтээн байгуулалт, засвар, судалгааны ажил Багц-1 Тохижилтын ажил”. Гэрээний дүн: 540.0 сая төгрөг. БЗД-ийн ЗДТГ нь ашиглагч байгууллагад хөрөнгийг хүлээлгэж өгөөгүй. /14 дүгээр сургуулийн хөл бөмбөгийн талбайны хашаа эвдрэлтэй, хаалгачийн тор урагдсан/

**Дүгнэлт:** Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд ашиглалтад хүлээж авсан даруйд нь үнэн зөв бүртгэх, тайлагнах ажиллагаа удаашралтай байна. Мөн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй байна.

---

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

---

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. ТАХ-г нийслэл, дүүргийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй уялдуулаагүй, хууль тогтоомжид заасан шаардлага хангаагүй ТАХ-г төсөвт тусган баталж байгаа нь хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх, ТАХ-ний уялдаа холбоог алдагдуулах сөрөг үр дагавартай байна.
2. Гүйцэтгэгч сонгон шалгаруулсан 97,948.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 352 ТАХ-ний 91.8%-ийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулжээ.
3. Аудитын түүвэрт хамрагдсан ТАХ-ээс 95.0 %-д нь захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн ч зарим ТАХ-нд хяналт хангалтгүй хэрэгжиж ажил дутуу болон чанаргүй хийгдсэн байна.

---

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

---

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### Дүүргүүдийн ИТХ-д:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд ТАХ бүрээр хуульд заасан шаардлагыг бүрэн хангуулж, шат шатны хяналтыг сайжруулж, хариуцлагатай, сахилга баттай байх зарчмыг мөрдөн ажиллах.

### Дүүргүүдийн Засаг дарга болон БГД, БЗД, СХД, ЧД-ийн Худалдан авах ажиллагааны албаны дарга нарт:

1. Хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу ТАХ-ний төлөвлөлтийг хийх;
